



ЗУУНМОД СУМЫН НЭГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

ҮАГ-ын Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Тэргүүлэх Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 7027-2582

И-мэйл Largalsaihan

Tuv@yahoo.com

Аудитор

Ц.Саранчимэг

Утас: 23204

И-мэйл

Tsaranchimeg@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын

ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	4
• Залруулаагүй алдаа	6
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	6
• Аудитын санал дүгнэлт	6

Зуунмод сумын Нэгдсэн тайлан 2013 оны Санхүүгийн Тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Зуунмод сумын Нэгдсэн тайлан 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Зуунмод сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаах бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Зуунмод сумын Засаг дарга тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Тайлант онд ОН Орлогот 182076,1 мянган төгрөгийн орлого төвлөрч орлогын төлөвлөгөө 67500,4 мянган төгрөгөөр давж биелсэн байна.
- Орон нутгийн төлөвлөгөө давсан орлогоос 33552,4 мянган төгрөгийг Зуунмод сумын ИТХ-ын тогтоолоор Багт 8336,6 мянган төгрөг, ИТХурал 8932,4 мянган төгрөг, ЗДТГ 16283,1 мянган төгрөг зардлын зүйлээр нэмж тодотгосон байна.
- ИТХурал хоолны зардлыг 727,6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Мөн Цалингийн зардал, ГХУСАХЗардал, бусад үардлын хэмнэлт 3837,8 мянган төгрөгөөр төлөвлөгдөөгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.
- Төсвийг хэмнэлтийг төвлөрүүлэлгүй ЗДТГазар 1436,8 мянган төгрөг, Баг 2905,9 мянган төгрөгийн хэмнэлтийг урьдчилж төлж авлага үүсгэсэн, бараа материал авсан нийт 4342,7 мянган төгрөгийг төлүүлэхээр акт бичигдлээ.
- Баг, ЗДТГазрын ажилтнуудад олгосон малын үнэ, түлээ нүүрсний хөнгөлөлтөөс 376,1 мянган төгрөгийн ХХОАТатвар аваагүй зөрчил илэрлээ.
- СХСангийн хугацаа хэтэрсэн болон зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй 77827,7 мянган төгрөгийн зээлийг

хураан эргэлтэнд оруулахаар албан шаардлага бичигдлээ.

- ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү
- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн илэрсэн алдаа зөрчилд 4238,8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 77827,7 мянган төгрөгийн албан шаардлагаар залруулж буй тул зөрчилгүй дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа
- Ерөнхий Аудитор 2013.03.27-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Төрийн сангийн төлөөлөгч Д.Алтанцэцэг Ахлах нягтлан бодогч Д.Мягмарсүрэн болон бусад бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Төв аймгийн Аудитын газар

2014.03.27

Танилцуулга

1.Бид Зуунмод сумын 2013 оны 12-р сарын 31 -ээр тасалбар болсон санхүүгийн тайланд Сумын ИТХурал, Каудитаа хийж бараг дуусаж байгаа ба Зуунмод сумын удирдлагад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна.Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Зуунмод сумын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

2.Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Зуунмод сумын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн.Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.Бид Зуунмод сумын Засаг даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4.Дээд түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Зуунмод сумын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилт

- Орон нутгийн орлогын төлөвлөгөө 114575.7 мянган төгрөгөөр батлагдсан.Тайлант онд ОНО-т 205032.3 мянган төгрөг төвлөрснөөс улсын тэмдэгтийн хураамж буцаан олгосон, нэр данс зөрүүтэй залруулагдсан нийт 22956,2 мянган төгрөгийг хасч тооцвол 182076,1 мянган төгрөгийн орлого төвлөрч орлогын төлөвлөгөө 67500,4 мянган төгрөгөөр давж биелсэн байна.
- НЕҮйлчилгээний төсвийг 2013 онд Аймгийн санхүүгийн дэмжлэгээс 401038,7 мянган төгрөг, Орон нутгийн орлогоос 114575,7 мянган төгрөг нийт 515614,4 мянган төгрөг зарцуулахаар баталсан байна. Гүйцэтгэлээр ЗДТГазар 312317,9 мянган төгрөг , ИТХурал 54370,4 мянган төгрөг , Баг 182478,5 мянган төгрөг , бүгд 549166,8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.
- Батлагдсан төлөвлөгөөнөөс 33552,4 мянган төгрөгийн санхүүжилт нэмж авсан нь ИТХТ-ийн 2013.02.08-ны 09 тоот тогтоолоор 4338,0 мянган төгрөг, ИТХ-ын 2013.03.28-ны 03 тоот тогтоолоор 2300,0 мянган төгрөг, ИТХТ-ийн 2013.05.01-ны 36 тоот тогтоолоор 1622,7 мянган төгрөг, ИТХТ-ийн 2013.05.24-ны өдрийн 39 тоот тогтоолоор 500,0 мянган төгрөгөөр, ИТХ-ын 2013.06.14-ны өдрийн 18972,2 мянган төгрөг, ИТХТ-ийн 2013.10.11-ний 72 тоот тогтоолоор 5819,2 мянган төгрөг төсөв тодотгосон байна.
- 2013 онд Орон нутгийн төлөвлөгөө давсан орлогыг Зуунмод сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгосоньг Багт 8336,6 мянган төгрөг, ИТХурал 8932,4 мянган төгрөг, ЗДТГ 16283,1мянган төгрөг , нийт 33552,1 мянган төгрөг нэмж хувиарласан байна.

Бараа үйлчилгээний урсгал зардал

- Бараа ажил үйлчилгээний зардал нь төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 124550.8 мянган төгрөг зарцуулсан байна.
- Ерөнхий журнаалаас sort filter –ийг ашиглан түүвэрлэхэд Зуунмод сумын ЗДТГазрын халаалтын зардал 1561,1 мянган төгрөгийг Багийн халаалтаас шилжүүлэн зарцуулсан байна. Төлбөр хураамжийн зардал 6469,7 мянган төгрөгийн зардлын гүйлгээг түүвэрлэн шалгахад 1891,7 мянган төгрөгийн цалин, 133,2 мянгн төгрөгийн НДШ, 168,0 мянган төгрөгийн хоолны зардлыг гаргасан байна.

- Мөнгөний гүйлгээний тайлангийн бусад зардал 12029,4 мянган төгрөгөөр тайлагнасныг түүвэр шалгахад 1499,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн зардлыг гаргасан мөн аймгийн ЗДТГазрын туслах аж ахуйн дансанд 1600,0 мянган төгрөг шилжүүлсэн байна.
- ЗДТГазар нь төсөвт зардал 312317,9 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 325628,7 мянган төгрөгийн зардал гаргаж 13310,8 мянган төгрөг хэтэрсэн нь бусад орлого 13342,3 мянган төгрөгийн гүйлгээтэй холбоотой байна.
- Баг 186403,9 мянган төгрөгийн төсөвт зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 174006,4 мянган төгрөгийн зардал гаргаж 12397,4 мянган төгрөг хэмнэгдсэн байна. Хэмнэлт нь цалингийн зардал 8575,9 мянган төгрөг, НДШимтгэл 3799,5 мянган төгрөг байна.
- ИТХурал бараа үйлчилгээний зардалд 730,0 мянган төгрөгийн хоолны зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 1457,6 мянган төгрөгийг хоолонд зарцуулж батлагдсан төлөвлөгөөг 727,6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Мөн Цалингийн зардлын 2252,0 мянган төгрөг, ГХУСАХ зардлын 1009,9 мянган төгрөг, бичиг хэрэг, ном хэвлэл, төлбөр хураамж, мэдээлэл сурталчилгаа, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын 575,9 мянган төгрөгийн тус тус хэмнэлтээс нийт 3837,8 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Цалин

- ЗДТГ-ын Цалингийн сан мөнгөн гүйлгээний тайлангаар 175556,9 мянган төгрөг, үр дүнгийн тайлангаар 176788,5 мянган төгрөг 1231,6 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь 1070,8 мянган төгрөгийн татварын өглөгтэй холбоотой байна.
- Цалингийн программаас нийт цалин шалгахад 176015,7 мянган төгрөгийн цалин олгож энэ нь үр дүнгийн тайлангаас зөрүүтэй байгаа цалингийн зардлаас тэтгэмж олгосонтой холбоотой байна.
- Ажилчдад олгосон урьдчилгаа, хуримтлалын мөнгөний суутгалыг нэг бүрчлэн тулган шалгалаа. Авсан урьдчилгааны тооцоог эцэслэн дуусаагүй байна. Ажилчдын цагийн балансын бүртгэлийг зохих журмын дагуу бүртгэсэн байна. Гэвч цалин бичихдээ цагийн балансаар бүртгэсэн ирцийн дагуу цалин бичигдэхгүй байна. ИТХурлын цалингийн зардлын хэмнэлт болох 2252,0 мянган төгрөгөөр компьютер, принтер худалдан авч үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Үндсэн хөрөнгө

- Зуунмод сумын Засаг даргын захирамжаар Жилийн эцсийн тооллого явуулах комиссыг томилон, тооллогын комиссууд ЗДТГ, багийн хөрөнгийг тоолж, тооллогыг хариуцлагатай хийж актлах хөрөнгийн жагсаалтыг нэр төрөл, дансаар үнийн дүнгээр гаргасан байна. Тайлант онд Зуунмод сумын НЕҮйлчилгээний үндсэн хөрөнгө нь 76395,8 мянган төгрөгөөр нэмэгдэж, данснаас 35704,6 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна. Хөрөнгийг хүлээн авсан акт шийдвэрийг үндэслэн дараахь хөрөнгийг холбогдох дансад орлогодсон байна. Үүнд:
- Барилга байгууламж дансанд 5-р багийн хүлэмж 5000,0 мянган төгрөг, 6- баг хашаа 5000,0 мянган төгрөг, Баянхошуу баг 6037,9 мянган төгрөг, шлгхгийн шийдвэрээр хураагдсан барилга 9968,4 нийт 26006,3 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч 1140,0 мянган төгрөгийн гүүрийг Хот тохижуулах газарт сумын ИТХТ-ийн 2009 оны 02 тоот тогтоолоор шилжүүлсэн байна. Авто тээврийн хэрэгсэлийн дансанд ХХААЯамнаас ирсэн прогон автомашин 20000,0 мянган төгрөг, 910,0 мянган төгрөгийн мотоцикл нийт 20910,0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан байна.
- Тоног төхөөрөмжийн дансанд багуудын чийрэгжүүлэлтийн танхимд хөрөнгө орлуулалтаар 3790,9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 2519,0 мянган төгрөгийн нөөтбүүк, скайнер, телевизор орлого авч сумын ИТХТ-ын тогтоолоор 17962,9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 8284,9 мянган төгрөгийн хөрөнгийг ИТХурал 2790,4 мянган төгрөг болон Хот тохижуулах газарт 5494,5 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.
- Тавилга эд хогшлийн дансанд 7151,0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч 2118,1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй ИТХурад шилжүүлсэн, 5928,6 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, 270,0 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсаныг төлүүлэхээр зарлагдсан нийт 8316,8 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна. Түүх соёлын дурсгалт зүйлсийн дансанд 2000,0 мянган төгрөгийн кино, манзушир хийдийн зураг 100,0 мянган нийт 2100,0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан байна. Программ хангамжийн дансанд 385,0 мянган төгрөгийн санхүүгийн программ орлого авсан байна.

- ИТХТ-ийн 2011.12.19-ны өдрийн 109 тоот тогтоолоор 16552,2 мянган төгрөг, ИТХТ-ийн 2013.06.14-ны өдрийн 46 тоот тогтоолуудыг 7369,4 мянган төгрөг үндэслэн нийт 23891,6 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна. ИТХурал тоног төхөөрөмжийн дансанд 6628,2 мянган төгрөг, тавилга эд хогшил 2118,1 мянган төгрөг нийт 8746,3 мянган төгрөгийн хөрөнгө орлого авсан байна. Хасагдсан үндсэн хөрөнгө байхгүй байна.
- Багийн авто тээврийн хэрэгсэл дансанд 910,0 мянган төгрөгийн мотоцикл, тоног төхөөрөмжийн дансанд 3907,2 мянган төгрөгийн нөөтбүүк, принтер зэрэг хөрөнгийг орлого авсан хасагдсан хөрөнгө байхгүй байна.
- НЕУ-ны хөрөнгийг тооллогыг хийж тооцоо бодсон актыг үйлдэж эд хариуцагч хөрөнгийг үлдэгдлийг хүлээн зөвшөөрч нягтлан бодогч баталгаажуулсан байна.

Бараа материал

- Зуунмод сумын НЕУ-ний бараа материалын дансны оны эхний үлдэгдэл 24466.2 мянган төгрөг, тайлант онд 33380.9 мянган төгрөгийн бараа материал орлогодож, 34618.7 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 23228.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.
- ЗДТГазар нь 18592,3 мянган төгрөгийн материал орлогодож 15431,1 мянган төгрөгийн бараа материал зарлагдсан байна. Зарлагдсан бараа мматериалаас 3815,1 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна. Оны эцэст тусгай зориулалттай бараа материал 2005,5 мянган төгрөг, ном 1100,3 мянган төгрөг, бичиг хэрэг 2203,7 мянган төгрөг, аж ахуйн материал 11088,8 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 735,0 мянган төгрөг, түлш шатах тослох материал 956,8 мянган төгрөг, бусад хангамжийн материал 160,6 мянган төгрөгийн нийт 18250,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Баг 10707,5 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал, түлш шатах тослох материал орлогодож, 15036,7 мянган төгрөгийн материал зарлагдсан байна. Багаас 451,5 мянган төгрөгийн бараа материал акталсан байна. Оны эцэст эм боох материал 215,0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1255,5 мянган төгрөг, аж ахуйн материал 1364,5 мянган төгрөг, түлш шатах тослох материал 1530,2 мянган төгрөг нийт 4365,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ИТХурал 4081,1 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал, түлш шатах тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материал орлогодож, 3699,4 мянган төгрөгийн материал зарлагдсан байна. Оны эцэст бичиг хэрэг 220,5 мянган төгрөг, аж ахуйн материал 257,4 мянган төгрөг, түлш шатах тослох материал 36,4 мянган төгрөг, хүнсний материал 36,0 мянган төгрөг, бусад хангамж 62,0 мянган төгрөг нийт 612,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна. Бараа материал дансанд хөтлөгдөх анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад тайлан гаргалт, баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудас зэргийг зохих журмын дагуу холбогдох албан тушаалтан гарын үсэг тамга тэмдэг дарагдсан эсэхийг шалгахад албажсан байна.

Авлага ,өглөгийн талаар

- Авлагын эхний үлдэгдэл 81712.4 мянган төгрөг үүнээс ЗДТГ-ын авлага 80535.3 мянган төгрөг, тайлант онд 169324.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 189211,7 мянган төгрөг хасагдаж оны эцэст 60648,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй .
- ЗДТГазрын авлагыг тулгаж үзэхэд 58800,0 мянган төгрөг нь Аймгийн ИТХ-ын 2010 оны 30-р тогтоолоор хувьчлагдсан боловч Дабль Эрдэнэ ХХК-ийн хүнсний цехэд олгосон 50000,0 мянган төгрөг нь төлөгдөөгүй үйл ажиллагаа нь зогссон шүүхэд шилжүүлсэн, Г.Цэвэлмаагаас 8800,0 мянган төгрөг нь төлөгдөж дуусаагүй тул авлагаар бүртгэлтэй байна. Төв Чандмань ОНӨУГазраас 296,3 мянган төгрөг, СЭБОЦЭ ХХК 560,0 мянган төгрөг, П.Бат-Аюуш 50,0 мянган төгрөг, Сүлд чоно ХХК 270,0 мянган төгрөг, бусад 662,0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Оны эцсийн ЗДТГазрын өглөгийг задлавал НДШимтгэл 659,5 мянган төгрөг, ХХОАТатвар 1070,8 мянган төгрөг, Алтан түрлэг 1320,0 мянган төгрөг, Сонгодог ХХК 1500,0 мянган төгрөг, Цахилгаан ШСГазар 2820,0 мянган төгрөг нийт 7370,3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.
- Баг оны эхэнд 1177,0 мянган төгрөгийн авлага, тайлант онд 23786,1 мянган төгрөгөөр нэмэгдэж , 22151,1 мянган төгрөгөөр хасагдаж 2812,1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Авлагыг задалвал Татварын хэлтэст 2001,1 мянган төгрөг, хувь хүнээс 476,0 мянган

төгрөг, Баталгаа Аудит ХХК –аас 335,0 мянган төгрөгийн авлагатай байна. Мөн урьдчилж төлсөн үардал дансанд 445,5 мянган төгрөгийн интернетийн төлбөр урьдчилж хийсэн байна. Баг 2103,5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 270447,7 мянган төгрөг нэмэгдэж, 272277,4 мянган төгрөгөөр өглөг хасагдаж оны эцэст 273,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

- ИТХУрал оны эхэнд авлагагүй оны эцэст 164,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй. Өглөг оны эхэнд үлдэгдэлгүй оны эцэст 801,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.
- Тооцоо нийлсэн актыг Зуунмод ХҮТ, НДХэлтэс, Төв Чандмань ДЭХГазартай тооцоо нийлсэн актыг үйлдсэн байна.
- Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 4,1-д “төсвийн жил нь тухайн оны 1-р сарын 1-ний өдрөөс эхэлж 12-р сарын 31-ээр дуусгавар болно” гэж заасан заалт нь тухайн жилийн төсөв нь зөвхөн тухайн жилдээ зарцуулах харилцааг зохицуулна гэснийг зөрчиж хэмнэгдсэн зардлыг харилцагч байгууллагад илүү төлж авлага үүсгэсэн мөн материал авч нөөцлөсөн байна. Үүнд ЗДТГазар 2013 оны 12-р сарын 31-ны байдлаар 956,8 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй, 480,0 төгрөгийн урьдчилж төлсөн зардал, Баг интернетийн төлбөрийг 445,5 мянган төгрөгөөр илүү төлсөн, ХХОАТатвар 930,2 мянган төгрөгөөр илүү төлсөн, 1530,2 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Иймд илүү төлсөн болон материал нөөцөлсөн 3862,7 мянган төгрөгийг төсөвт төлүүлэхээр акт бичигдлээ.

Мөнгөн хөрөнгө

- НЕҮйлчилгээний мөнгөн хөрөнгийн журналаас эхселийн sort filter –ийг ашиглан тулгалтыг хийхэд тайлант онд ЗДТГ-т-7025,2 мянган төгрөг, ИТХУрал 33,8 мянган төгрөг, Баг 16192,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ЗДТГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь хөрөнгө оруулалтын үлдэгдэл байна. Багийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь цалин, шимтгэлийн зардлын хэмнэлтийн үлдэгдэл байна.
- Мөнгөн хөрөнгийн зарцуулалтын байдалд түүвэрлэн шалгахад Баг, ЗДТГазрын ажилтнуудад олгосон малын үнэ, түлээ нүүрсний хөнгөлөлтөөс 376,1 мянган төгрөгийн ХХОАТатвар аваагүй зөрчил илэрлээ.
- Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлж дансны үлдэгдэл нь төрийн сангийн хуулгатай тохирч гарсан байна.

Тусгай сангууд

- Зуунмод сум оны эхэнд 4 санд нийт 35510,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 504213,5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 201362,5 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 338461,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Сум хөгжүүлэх сангийн харилцахын үлдэгдэл 31801,8 мянган төгрөг 498377,0 мянган төгрөг төвлөрүүлснээс 199311,6 мянган төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 13765,4 мянган төгрөгийн хүүгийн орлого оруулж, 285300,0 мянган төгрөгийн санхүүжилт ирж нийт эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Тайлант онд тус сангаас 193900,0 мянган төгрөгийн зээл олгож, цалинд 3620,1 мянган төгрөг, ашиглалтын зардалд 1078,0 мянган төгрөг, шатахуунд 335,0 мянган төгрөг нийт 198598,4 мянган төгрөгийг зарцуулж 331580,4 мянган төгрөгнийн харилцах дансдаа үлдэгдэлтэй байна.
- Сум хөгжүүлэх сангийн оны эхэнд 364448,0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байснаас тайлант онд 193900,0 мянган төгрөгийн зээл олгогдож 213077,0 мянган төгрөгийн үндсэн зээл, хүүгийн хамт төлөгдсөнөөс оны эцэст 363446,1 мянган төгрөгийн 114 иргэний зээлийн авлагатай байна. Нийт авлагыг задлавал өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн авлага 33 хүнтэй холбоотой 17,6-4000,0 мянган төгрөгийн нийт 40858,9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 81 иргэнтэй холбоотой 9,3-18937,2 мянган төгрөгийн нийт 322587,2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн бүртгэл хөтлөлт эргэн төлөлтөнд тавих хяналт хангалттай хийгдэж байна. Гэвч өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн 40858,9 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, мөн сум хөгжүүлэх сангийн зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаад нь тавих хяналт хангалтгүй байна. Иймд хугацаа хэтэрсэн болон зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй 77827,7 мянган төгрөгийн зээлийг төлүүлэн Сум хөгжүүлэх санд төвлөрүүлэн

- дахин эргэлтэнд оруулахаар албан шаардлага бичигдлээ. Сум хөгжүүлэх сан нь 2013.12.31-ны байдлаар нийт 695077,5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.
- “Мал хамгаалах сан” оны эхэнд харилцах дансанд үлдэгдэлгүй тайлант онд 225,0 мянган төгрөгийн өвсний мөнгө орж 225,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн тайлант оны эхэнд 3000,0 мянган төгрөгийн өвсний үлдэгдэлтэй тайлант онд нэмж өвс худалдан аваагүй, 225,0 мянган төгрөгийн зарж борлуулан оны эцэст 2775,0 мянган төгрөгийн өвсний үлдэгдэлтэй байна. Өвсний үлдэгдлийг жилийн эцсийн тайлангаар тоолсон боловч өвсний тооцоог бодоогүй байна. Мал хамгаалах сан нь 2013.12.31-ний байдлаар нийт 3000,0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.
 - ГХУССан оны эхэнд 1180,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, ИТХурлын санхүүжилт болон аймгийн ГХУССангаас 4158,5 мянган төгрөг, архи тамхины зөвшөөрөл 1453,0 мянган төгрөг нийт 5611,5 мянган төгрөгийн орлого эх үүсвэр бүрдүүлсэн байна. Тайлант онд 1082,5 мянган төгрөгийг зарцуулснаас 293,0 мянган төгрөгийг шатахуунд, 341,5 мянган төгрөгийг хуулийн сурталчлах тэмцээний шагналд, 108,0 мянган төгрөгийг томилолтонд зарцуулж 5709,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
 - БХСан оны эхэнд 2527,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, МХГазрын актаар 1521,6 мянган төгрөгийг төсвийн орлогын данс руу буцаан шилжүүлсэн, нийтийн эзэмшлийн зам талбай, гудамжны цэвэрлэгээний хог ачих авто тээврийн хэрэгслийн шатахуунд 60,0 мянган төгрөг зарцуулж 946,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эдгээр асуудлуудыг ААГ болон Зуунмод сумын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаарх санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5.Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Байгууллагын төсвийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах
- Төсвийн зардлаар төлөвлөгдөөгүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх

6.Эдгээр асуудлуудыг ААГ болон Зуунмод сумын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7 Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. ЗДТГазар 5234,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, ИТХурал 3837,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн зөрчил нь залруулагдаагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8 Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх зөвлөмжийн биелэлт

2011 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн байна

1. МУ-ын ЗГазрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах
2. Орон нутгийн ерөнхий орлогын данснаас зарлагын гүйлгээ хийхийг зогсоох.
3. Ажиллагсдаар цалингийн хүснэгтэнд гарын үсэг бүрэн зуруулж хэвших.
4. ТБУСТХуулийн 16.2.12-дах аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн ерөнхий менежер байна гэж заасныг зөрчсөн байна.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг Аймгийн Аудитын газарт албан бичгээр ирүүлэхдээ хэрэгжүүлж ажилласан тухайгаа мэдэгдсэнийг энэхүү аудитын явцад дахин шалгалаа. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2013.03.26